



Mongolia:  
Enhancing Resource  
Management through  
Institutional Transformation

Үр дүнд суурилсан удирдлага  
(ҮДСУ)-ын аргад хүрээлэн буй  
орчны асуудлыг тусгах нь

Техникийн зөвлөх, илтгэгч:  
Raymond Gervais/Раймонд Жербэй



---

# Зорилго

Энэхүү сургалтын зорилго нь **хүрээлэн буй орчны** үндсэн үзэл ойлголтуудыг Үр дүнд суурилсан удирдлагын аргатай холбон танилцуулах явдал юм.

# Хүлээгдэж буй үр дүн

- Оролцогчид **хүрээлэн буй орчны холбогдолтой ойлголтуудын тодорхойлолт болон зарчмын талаар** илүү сайн ойлголттой болно.
- Мөн хүрээлэн буй орчин болоод үр дүнд суурилсан удирдлагын үйл явц, арга хэрэгсэл хооронд **уялдаа холбоо** бий болгох юм.
- Хүрээлэн буй орчинд холбогдуулан **үр дүнгийн гинжин хэлхээ** гэх ойлголттой танилцана.
- **ЭЗХАХБ**-ын байгаль орчны шалгуур үзүүлэлтүүдийг үзнэ.

# Тодорхойлолт

Википедиа цахим сайтад нийтэлснээр хүрээлэн буй орчны хоёр төлвийг тодорхойлж болно. Үүнд:

“**Байгаль орчин** гэдэгт байгаль эхийн бүтээсэн бүх амьтай ба амьгүй зүйлсийг хамруулдаг бөгөөд энэ тохиолдолд хүний оролцоотой зохиомол бүс гэсэн утгатай. Уг орчинд хүний амиа хоохойлох болон эдийн засгийн үйл ажиллагаанд нөлөөлдөг бүхий л амьд амьтан, ургамлын төрөл зүйл, уур амьсгал, цаг агаар болон байгалийн нөөц баялаг хоорондын **харилцан үйлчлэлийг** хамааруулдаг.

Дээрхийн эсрэг орчин нь **хүний бүтээсэн орчин** юм. Ийм газарт хүн төрөлхтөн байгалийн ландшафтыг хотын бүс болон ХАА-н зориулалттай газар болгон үндсээр нь **хувиргаж**, байгаль орчинг хялбаршуулан хүний орчин болгон ихээр өөрчилж байна.

# Хүрээлэн буй орчныг удирдах нь

Үр дүнд суурилсан удирдлагыг аль аль төлөвт нь ашиглах ёстой.  
Үүнд:

- Хүрээлэн буй орчинд ҮДСУ нь төсөл хэрэгжүүлж, явуулах **сөрөг** нөлөөллийг бууруулах замаар тухайн орчинд үзүүлэх **үр нөлөөг** илүү сайн удирдахыг чармайдаг.
- Хотын бүс зэрэг хүний бүтээсэн орчинд энэ нь хүний хөгжлийг тогтвортой тэтгэх байгалийн нөөц бололцоог **хадгалахын** зэрэгцээгээр хүний суурин амьдралыг **сайжруулах** хамгийн сайн хувилбарыг олж тогтооход туслах юм.

Аль алинд нь ҮДСУ-ын арга, аргачлал нь хүрээлэн буй орчин болон нийгмийн зүгээс хүлээн зөвшөөрөгдсөн **зорилтуудыг** тодорхойлж, зэрэг болон сөрөг **үр дүнг** хэмжихэд тусалдаг.

# Үндсэн ойлголт

**Хүрээлэн буй орчны эрсдэл:** Аливаа байгууллагын **үйл ажиллагаанаас** гарсан бохир ус, хорт хий ялгаруулалт, хог хаягдал, нөөц шавхагдах гэх мэтээс үүдэн амьд организм болон хүрээлэн буй орчинд бодитоор үүсч буй сөрөг нөлөө эсвэл аюул үүсч болзошгүй гэх заналхийлэл юм.

Эх сурвалж: <http://www.businessdictionary.com/definition/environmental-risk.html>

ҮДСУ-ын аргад хүрээлэн буй орчны асуудлыг тусгахдаа аливаа төсөл/хөтөлбөрийн улмаас хүрээлэн буй орчинд үүсч буй эрсдэлийг үнэлж, улмаар тэдгээрийг бууруулахад туслах **шалгуур үзүүлэлтүүдийг** тодорхойлох замаар гүйцэтгэх ёстой.

Хамтдаа нэг зохиомол жишээ харцгаая.

# Хүрээлэн буй орчин ба үр дүнгийн гинжин хэлхээ

Үр дүнгийн гинжин хэлхээ: ХАА, МАА-н зориулалттай худаг гаргах

## Төлөвлөлт

| Үр дүнгийн гинжин хэлхээ | Орц: Хөрөнгө санхүү, эд материал ба мэргэжилтэн  | Үйл ажиллагаа: Байгаль орчны үнэлгээ болон ҮА-ны байршлын төлөвлөгөө                                  |
|--------------------------|--|---|
| Асуудал/асуулт           | Зорилтот бүсийн усны нөөцийн байдал. Нөөц нь усны хэрэглээний өсөлтийг тогтвортой хангаж чадах уу? | Худаг гаргах боломжит газрын байршил, тархалт. Суурин газар, хүн амын нягтралд ямар нөлөө үзүүлэх вэ? |
| Эрсдэл                   | Өрөмдлөгийн үйл ажиллагаанаас бохирдох. Усыг урт хугацаанд хэт их хэрэглэх                         | Тариаланч, малчид зэрэг хэрэглэгчдийн хоорондын тэмцэл гарах  |
| Шалгуур үзүүлэлт         | Усны нөөцийн суурь үнэлгээ   | Худгийн зурагзүй болон суурьшлын бүсээс худаг хүртэлх дундаж зай                                      |
| Бууруулах стратеги       | Ан цавын усны бүс, хагарлын бүртгэл зэрэг мэдээлэлд баримтын судалгаа хийх                         | Ан цавын усны бүс, хүний суурьшлыг <u>оролцуулан</u> сайн суурь судалгаа хийх                         |

# Хүрээлэн буй орчин ба үр дүнгийн гинжин хэлхээ

## Богино хугацааны үр дүн

| Үр дүнгийн гинжин хэлхээ | Гарц: Газарзүй болон нийгмийн үзүүлэлтэд тулгуурласан худгийн тоо нэмэгдсэн   | Завсрын үр дүн: Олон зорилгод шууд савлан хэрэглэх боломжтой усны хүртээмж нэмэгдсэн  |
|--------------------------|---|---|
| Асуудал/асуулт           | Хэрэглэгчид хоорондоо зөвшилцөж, Харилцан ойлголцлын санамж бичиг (ХОСБ)-ийг байгуулах шаардлагатай. ХОСБ маргаан үүсэх эрсдэлийг бууруулахад хэрхэн тусалж чадах вэ? | Хүртээмж нэмэгдсэнээр тогтвортой байдлын асуудал урган гарна. Худаг бүрийн засвар арчилгааг хийх үү? Хэрэв үгүй бол үр дагавар нь юу байж болох вэ? |
| Эрсдэл                   | Усны ундарга нь татрах эрсдэлд бага анхаарал хандуулж, худгаас хэт олон хүн ус хэрэглэх   | Ундарга нь муудсан, бохирдсон худаг нь хэрэглэгчид худгаа сайн арчлахад хүргэнэ.  |
| Шалгуур үзүүлэлт         | Хэрэглэгчдийн статистикийг сар бүр хүйсээр болон ашиглалтын төрлөөр (газар тариалан, МАА) ангилан гаргах  | Бүх гаргасан худагт бохирдлын түвшинг сар бүр хэмжих. Усны таблицыг байдлыг жил бүр үнэлэх  |
| Бууруулах стратеги       | Нийгмийн болон байгаль орчны эрсдэлийг таниулахын тулд орон нутгийн ард иргэдийг хөдөлгөөнд оруулах   | Тосгоны техникчдыг бохирдлын түвшинг хэмжих чадвартай болгон сургахаар төсөлд оруулах.  |



# Хүрээлэн буй орчин ба үр дүнгийн гинжин хэлхээ

## Урт хугацааны үр дүн

| Үр дүнгийн гинжин хэлхээ | Завсрын үр дүн: Газар тариалан болон МАА-н үйлдвэрлэл өссөнөөр ард иргэдийн орлого нэмэгдэх  | Эцсийн үр дүн: Орон нутгийн иргэд, мал амьтны эрүүл мэнд сайжрах  |
|--------------------------|--|---|
| Асуудал/асуулт           | Худгийг арчлах, худгийн орчинг сайжруулахад зориулан нэмэгдсэн орлогоос хөрөнгө хуваарилна. Хэрэглэгчид тусгай сантай байх хэрэгцээ шаардлагыг олж харах үү? | Хүрээлэн буй орчноос үүдэлтэй эрүүл мэндэд заналхийлж буй бусад аюулыг хянах. Бохирдлын ерөнхий түвшин нь савлах боломжтой усны хүртээмж нэмэгдсэнээс гарах эерэг нөлөөг хязгаарлах үү? |
| Эрсдэл                   | Худгийн орчин тойрны хамгаалалтыг урт хугацаанд хангахгүй байх   | Эрүүл мэндийн үйлчилгээ нь байгаль орчны асуудлуудын харилцан холбоог тогтоох боломжгүй байх.   |
| Шалгуур үзүүлэлт         | Тосгодод байгаа Худгийн тусгай сангийн хөрөнгөнд жил тутам санхүүгийн аудит хийх   | Эмнэлэгт хэвтэн эмчлүүлсэн хүмүүсийн тоог хүйс болон өвчнөөр нь сар бүр гаргах  |
| Бууруулах стратеги       | Эхнээсээ төсөл нь буурай орон нутгийн иргэдэд тусгай сан байгуулахад туслах санхүүгийн нөөцтэй байх.   | Сургалт явуулах замаар хүрээлэн буй орчны хүний эрүүл мэндэд үзүүлэх нөлөөллийн талаарх эрүүлийг хамгаалахын ажилтнуудын ойлголтыг шинэчлэн сайжруулах төлөвлөгөө                       |

# Байгаль орчин, УДСУ: Монгол улс

УДСУ-ыг байгаль орчны асуудалд ашиглаж болох болов уу?

Байгаль орчинд нөлөөлөх байдлын тухай хуульд энэ үнэлгээнд ямар ямар үнэлгээ орохыг заасан байдаг. Үүнд:

Байгаль орчны стратегийн үнэлгээ;

Байгаль орчны суурь үнэлгээ;

Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ;

Хуримтлагдах нөлөөллийн үнэлгээ.

Энд заасан бүрэлдэхүүн хэсгүүд нь УДСУ-ын аргатай зарим ойлголтыг/үзэл баримтлалыг адилхан хэрэглэдэг.

# Байгаль орчны шалгуур үзүүлэлтүүд: Олон улсын чиг хандлага 1

**ЭЗХАХБ**-ын ажилд 3 гол суурь шалгуур үзүүлэлтийг ашигласан. Үүнд: бодлогын хамаарал ба хэрэглэгчдэд тустай байх, сайн дүн шинжилгээ хийж болохуйц, хэмжигдэхүйц байх

Аливаа байгаль орчны шалгуур үзүүлэлт нь:

1. Бодлогын хамаарал ба хэрэглэгчдэд тустай байх
  - Байгаль орчны төлөв байдал, байгаль орчинд учруулж буй хүндрэл, түүний хариуд нийгэм хэрхэн хандаж байгааг төлөөлөн харуулах дүр зураг гарган өгөх;
  - Энгийн, хөрвүүлэхэд хялбар, цаг хугацаа өнгөрөхөд хандлага ямар байгааг харуулах боломжтой байх;
  - Байгаль орчинд гарч буй өөрчлөлт болоод холбогдох хүний үйл ажиллагаанд мэдрэмжтэй байх;
  - Олон улсын түвшинд харьцуулалт хийх суурь болж өгөх;
  - Цар хүрээний хувьд нэг үндэстнийг хамарсан эсвэл үндэстний ач холбогдолтой бүсийн түвшний байгаль орчны асуудалд хамааралтай байх;
  - Харьцуулж болохуйц босго, суурь утгатай байх. Ингэснээр хэрэглэгчид харгалзах утга нь ач холбогдолтойг үнэлж чадах юм.

# Байгаль орчны шалгуур үзүүлэлтүүд: Олон улсын чиг хандлага 2

## 2. Сайн дүн шинжилгээ хийж болохуйц

- Онолын хувьд мэргэжлийн болон шинжлэх ухааны ойлголтод сайн тулгуурласан байх;
- Хүчин төгөлдөр байдлын хувьд олон улсын стандарт, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн аргад тулгуурласан байх;
- Эдийн засгийн бүтэц, хэтийн төлөв, мэдээллийн системтэй уялдсан байх.

## 3. Хэмжигдэхүйц байх

- Бэлэн байгаа эсвэл боломжийн зардлаар олж авч, гаргасан зардлаас нь давсан үр шим хүртэх боломжтой байх;
- Зохих байдлаар баримтжуулсан бөгөөд чанар нь баталгаажсан;
- Батлагдсан горимын дагуу тодорхой хугацааны давтамжтай байнга шинэчилж байх.

Эх сурвалж: OECD Environmental Indicators – Development, Measurement and Use. 2003.

**Асуулт: Эдгээрийн аль нь төслийн түвшинд ҮДСУ-ын аргад тустай байх вэ?**

# Байгаль орчны шалгуур үзүүлэлт

Дасгал ажил:

1. Сайн байгаль орчны бүрдэл бүхий нэг төслийг тодорхойлж, товч танилцуулна уу (нэр, хамгийн ихдээ 5 мөр тайлбар)
2. Тухайн төслийн үр дүнтэй холбогдсон 5 шалгуур үзүүлэлтийг бичнэ.
3. Тэд ЭЗХАХБ-ын шалгуур үзүүлэлттэй хэрхэн холбогдож буйг хэлнэ үү.

“БАЯРЛАЛАА”